

**Герман Улсад суралцсан монгол оюутан, сурагчдын
түүхэнд холбогдох зарим тэмдэглэл
(1926-1930 он)**

Р. Төрдалай (МУИС)

1. Баруун Европ дахь БНМАУ-ын боловсролын үйл ажиллагааны эхлэл тавигдсан нь

Одоогоос наяд жилийн тэртээ Баруун Европт монгол хөвгүүд, охидыг анх илгээсэн нь тухайн үеийн БНМАУ-ын хувьд түүхэн зоримог алхам болсон юм. Хэдийгээр бага насны, цөөхөн хүүхдүүдийг Баруун Европт суралцуулахаар илгээсэн нь төдий л анхаарал татах зүйл биш боловч энэхүү үйл явдлыг тухайн үеийн БНМАУ-ын улс төрийн нөхцөл, түүнээс улбаалсан цаг үеийн ээдрээтэй байдалтай холбон авч үзвэл түүхэн ач холбогдол нь тодрон харагдах ажээ. Миний бие энэ өгүүлэлд монгол сурагчдын Герман оронд хэрхэн дасан зохицож байсан хийгээд тэдний ахуй байдлын тухай олон сонирхолтой асуудлыг багтаан өгүүлэх боломжгүй бөгөөд зөвхөн тэдний боловсрол, сургалтын асуудалд голлон анхаарлаа хандуулах бодолтой байна.

1921 оны Үндэсний Ардчилсан Хувьсгалын дараагаар БНМАУ-ын гадаад бодлогын үндсэн чиглэл нь Зөвлөлт Орос Улсаас гадна нийгмийн байгуулал, үзэл суртлын ялгааг үл харгалзан Европын Герман, Франц зэрэг орнуудтай худалдаа, эдийн засаг, соёл боловсролын салбарт өргөн харилцаа тогтоон хөгжүүлэх, цаашилбал тусгаар тогтнолоо албан ёсоор хүлээн зөвшөөрүүлж, төрийн харилцаа тогтооход чиглэгдэх болсон юм. 1923 оны VII сарын 24-нд тусгай комиссын боловсруулан нийтэлсэн "Эдийн засгийн үндсэн бодлого"-ын 15-р зүйлд аж үйлдвэр, техник, технологийн арга ажиллагаанд суралцсан дунд, тусгай, дээд түвшний үндэсний боловсон хүчинг гадаад улсуудад бэлтгэн сургахаас өөр аргагүйг болсон тухай заан тэмдэглэх болжээ¹. Иймээс Герман Улсын холбогдох албаны хүмүүстэй ярилцаж тохиролцсоны дагуу 1925 оны IV сард Засгийн газрын шийдвэрээр Даш Сампилон, Хурлат нар худалдааны төлөөлөгчдөөр томилогдон Герман Улсад очиж худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох асуудлаар хэлэлцээр хийж чамламгүй амжилт олсны зэрэгцээ Герман Улсад оюутан, сурагчдаа илгээх тухай үндсэн тохиролцоонд хүрсэн байна².

БНМАУ-ын Засгийн газар анхнаасаа Герман Улстай тогтоох худалдаа, эдийн засаг, соёл боловсролын харилцааны агуулгыг хооронд нь нарийн уялдуулахыг эрмэлзэж байсан юм. Худалдааны төлөөлөгчдийн айлчлалын үр дүнд 1925 оноос цахилгаан, эрчим хүч, мод, төмөрлөг, барилгын материал боловсруулах салбар, хэвлэлийн үйлдвэрлэл, уул уурхай, ашигт малтмал, авто тээвэр, худалдаа ба ахуйн хэрэглээ, үйлчилгээ зэрэг өргөн чиглэлд Герман Улстай хамтран ажиллах болсноор герман мэргэжилтнүүд гэрээгээр БНМАУ-д ирж ажиллан хөгжингүй орны техник, технологи Монголд нэвтрэх үүд хаалга нээгдсэн байна. Гэвч тухайн үеийн манай Засгийн газрын өмнө тулгарсан гол бэрхшээлтэй асуудал нь өөрийн үндэсний чадварлаг боловсон хүчин дутагдалтай байсан явдал бөгөөд нэгэнт Герман Улстай худалдаа,

¹ Монгол Ардын Намын хоёрдугаар Их хурал (*Баримт бичгүүд*), Улаанбаатар, УХГ, 1974, 139-р тал

² МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6. *Монгол-Германы харилцааны данс* – 1-1д, нугалбар № 40.

эдийн засгийн өргөн харилцаа тогтоох замыг сонгосон тул харилцаа тогтоосон чиглэлүүдийнхээ дагуу оюутан, сурагчдыг илгээн суралцуулахыг давын өмнө чухалчлан шийдвэрлэх хэрэгтэй болжээ.

1925 оны XI сарын 27-ны өдрийн Ардын Засгийн газрын хуралдаанаас гаргасан 42-р тогтоолд "... хичээл сурлагадаа шалгарсан биеийн эрүүл мэндийн хувьд тэнцэх дунд сургуулийн төгсөх ангийн 35 сурагчийг сонгон авч Герман, Франц Улсад явуулж суралцуулах" шийдвэр гаргасан билээ¹. 1926 оны V сарын 21-ний өдрийн Үнэн сонин № 28-ны дугаарт "Бас нэгэн алхам урагшлав" нэртэйгээр хэвлэгдсэн өгүүлэлд Герман, Франц Улсад суралцуулахаар явуулсан монгол сурагчдыг Намын Төв Хорооны дарга Ц.Дамбадорж, Ерөнхий сайд Б.Цэрэндорж, сайд Амар, Судар бичгийн хүрээлэнгийн дарга Ж. Цэвээн нар үдэж мордуулсан тухай бичсэн нь тухайн үед уг асуудалд төрийн хэмжээнд ач холбогдол өгч байсныг гэрчилнэ².

БНМАУ-ын багш сурагчдыг Герман Улсад хүргэж, тэдэнтэй холбогдох асуудлыг зохицуулах үүргийг эхний үед Ардыг Гэгээрүүлэх яамны сайд Эрдэнэбатхаан голлон хариуцаж ажилласан бөгөөд тэрээр Берлин хотын зүүн хойд захад орших Фронау /Fronau/ гэдэг хөдөө байдалтай газар нэгэн герман айлын байшинг хөлслөн авч багш, сурагчдаа суулгахаар хэлэлцэн тохиролцож гэрээ байгуулснаар 1926 оны VI сарын 14-ний өдөр Монголын багш, сурагчдыг уг байранд шилжүүлэн суулгажээ³. Монгол сурагчид Фронауд 1927 оны I сар хүртэл байх хугацаандаа анх Ардыг Гэгээрүүлэх Яамнаас төлөвлөсөн ёсоор герман хэл, бичигт сайтар суралцаж, дараа нь тус тусын сургуульд суралцах даалгавартай байжээ. Тэдэнд Даллер зэрэг хоёр багшийг хөлслөн авч герман хэл, бичгийг заалгаж байв.

1926 оны VI сараас 1927 оны I сар хүртэлх энэхүү 8 сарын хугацааг монгол сурагчдыг Герман Улсын дунд, тусгай мэргэжлийн сургуульд элсүүлэн суралцуулахаар бэлтгэж байсан үе гэж үзэж болно. 1925 оны XI сарын 27-ны өдрийн Ардын Засгийн газрын 42-р тогтоолыг үндэслэн Ардыг Гэгээрүүлэх Яамны зохистой төлөвлөгөөний дагуу дээрх сурагчдын сургуулийн төлбөр, бусад зардлыг Засгийн газар бүрэн хариуцахаар тогтсон байна. Сурагчид герман хэлний бэлтгэлд сурсныхаа дараа ерөнхий боловсролын сургууль, БНМАУ-ын Засгийн газартай худалдааны гэрээ байгуулсан үйлдвэр, заводуудад мэргэжлийн дадлага, сургууль хийж суралцах төлөвлөгөөтэй байжээ. 1926 оны XI сараас эхлэн Фронаугаас Аюурзана, Лувсандамдин нарын сурагчдыг Лайпциг хотын газарзүйн зургийн *Wagner&Debes* пүүст ажиллуулахаар анхлан явуулж эхлэсэн ба 1927 оны I сарын байдлаар монгол сурагчид дунд сургууль болон дээрх гэрээт үйлдвэрүүдэд ажиллаж, суралцах явдал үндсэндээ жигдэрч шийдэгджээ.

Сургуульд хуваарилагдсан байдлыг авч үзвэл Берлин /Berlin/ хотын Лихтерфельде дүүрэгт орших Улсын Сургалтын байгууллага /Staatliche Lehranstalt in Lichterfelde/ -ын дунд сургуульд С. Бавуу, С. Наваан-Юндэн, Пүрэвдорж, Доржсүрэн, Б. Содном (том) нарын сурагчид, мөн хотын Кино-гэрэл зургийн Уфа нэгдлийн сургуульд Н. Бат-Очир, Лайпциг /Leipzig/-ийн Их Сургуулийн сэтгүүлчийн салбарт хувийн тохиролцооны дагуу Д. Нацагдорж, мөн хотын газарзүйн зургийн *Wagner&Debes* пүүст Аюурзана, Лувсаннамжил нар, мөн Arno Pries & I.B. Hirschfeld хэвлэлийн пүүст Ц. Баатарсэнгэ, С. Лувсандамдин, Охидийн лицей /Hohere Tochter (Mädchen) schule /-д Д. Пагамдулам, Залфельд /Saalfeld/ хотын Виккерсдорфын чөлөөт сургуульд Дорж, Гомбо, Д. Намдаг, Л. Намхайцэрэн, Бадарчин, Сэдэд, Т. Нацагдорж, Х. Цэвээн, Г. Батсүх, Г. Халаа, Цэрэнханд нарын арван нэгэн сурагч, Айзнах /Eisenach/ хотын Dixi автомашины үйлдвэрт Базарням, Лувсан нар, Лецлинген /Letzlingen/ хотын гар үйлдвэрлэлийн хамтлагт М. Лувсанцэнд, Ш. Цэвэг, Д. Сурмаажав, Юмхүү нар, Ораниенбург /Oranienburg/ хотын Хөдөө Аж ахуйн Сургалтын Байгууллага /Landwirtschaftliche Lehranstalt in Oranienburg-Luisenhof/-т Д. Санжаа, Фрайберг /Freiberg/ хотын арьс шир боловсруулах үйлдвэрийн сургуульд И. Содном(бага), Сумади, Юмбүү нар, Штутгартын ойролцоо Мюлакерт /Muehlacker/-ын Messrs.Haendle & Sons-ын тоосгоны завад нэр бүхий хоёр сурагч, Котбус /Cottbus/ хотын нэхмэлийн сургуульд Гомбожав, Сумъяа нар тус тус хуваарилагдан суралцах болсон байна.

¹ УТА, Фонд № 11, данс. 2, хадгаламжийн нэгж - 4, хуудасны дугаар - 126-127.

² УТА, Үнэн сонин, 1926 оны V сарын 21. дугаар № 28.

³ МАХН-ын Төв Архив, Фонд № 4, данс-2, хадгаламжийн нэгж -5.

Хэдийгээр Баруун Европ дахь БНМАУ-ын боловсролын үйл хэрэг ийнхүү нааштайгаар шийдэгдсэн мэт боловч МАХН-ын V их хурлын тайлан илтгэлүүдэд /1926 оны IX сарын байдлаар/ ЗХУ, Герман, Франц зэрэг улсуудад нийт 85 хүн суралцаж байгааг дурьдаад 1926-1927 онд 66 оюутан, сурагчдыг нэмж сурахаар төлөвлөснөөр гадаадад сургуульд суралцагсдын тоо 151¹ болсон байна. Гэвч энэ нь тухайн үед манай улсад нэн шаардлагатай байсан тусгай мэргэжлийн боловсон хүчний хэрэгцээнээс бараг хоёр дахин бага үзүүлэлттэй байжээ. Иймээс Засгийн газар, Ардыг Гэгээрүүлэх яамнаас гадаадын сургуулиудад суралцах сурагчдын тоог тасралтгүй нэмэгдүүлэхийг дэмжиж байв. 1926 оны IX сарын 11-ний өдөр Намын Төв Хорооны Зохион Байгуулах Зөвлөлийн 24-р хурлаас Д.Нацагдорж, Пагмадулам, Пунцаг, Лувсанчүлтэм, Санжаа, Бат-Очир нарын 6 хүнийг Герман Улсад явуулж сургах шийдвэр гаргасан байна². Ийнхүү Герман, Франц Улс дахь сурагчдын тоо нийтдээ 44 хүрсэн байна. 1927 оны Улсын III Их хурал, 1926 оны IX сарын 26-наас X сарын 3-ны өдөр хүртэл хуралдсан МАХН-ын V Их хурлын шийдвэрүүдэд үндэслэн 1927-1936 он хүртэл жил тутамд гадаадад суралцагчдын тоог 20-иор нэмэгдүүлэх замаар 1937 онд 280-д хүргэх зорилтыг дээрх төлөвлөгөөнд баталсан бөгөөд гадаадад суралцагчдын төсвийг 20 сая төгрөгт багтаан төсөвлөсөн байна³. Герман, Франц Улс дахь нэг сурагчийн жилийн зардал 2230,21 төгрөг байсан бол Москва дахь нэг сурагчийн жилийн зардал 166,66 төгрөг⁴ байсан нь Герман, Франц Улс дахь сурагчдын зардал сүйтгэл нь ЗХУ-д суралцагчдаас үлэмж их байсан нь тодорхой байдаг.

2. Д. Нацагдоржийн Герман Улс дахь сургалт, судалгааны үйл ажиллагаа

Герман Улсад суралцагчид, тэдний ахуй байдал, хэрхэн суралцаж байсан тухай Монгол Улс, ХБНГУ-ын холбогдох архивуудад баримт материал цөөнгүй байдаг бөгөөд ялангуяа "Герман, Франц Улс дахь Монгол сурагчдын захиргаа"-ны дарга Б. Ишдорж багшид явуулж байсан сурагчдын захидал, бусад холбогдох баримтуудад тодорхой тэмдэглэгдэн үлджээ⁵. Мөн Б. Ишдоржийн зөвлөхөөр ажиллаж байсан С. М. Вольф* хожим дурсамж өгүүлэлүүддээ энэ тухай тодорхой бичиж үлдээжээ⁶. С. М. Вольфийн дээрхи дурсамж өгүүлэлүүд нь Герман, Франц Улс дахь БНМАУ-ын боловсролын үйл хэрэг, Баруун Европт суралцсан монгол сурагчдын түүхийг мөшгин судлахад өдгөө чухал ач холбогдолтой түүхэн сурвалж болж байна.

Манай улсын шинэ үеийн түүх бичлэгт өргөн далайцтайгаар судлавал зохих асуудлын нэг бол Д. Нацагдоржийн Герман Улсад суралцсан жилүүдийн судалгаа юм. 1930-иад онд Герман Улсын дунд, тусгай мэргэжлийн сургуулиудад сурагчдыг голлон илгээж байсан нь үнэн боловч Д. Нацагдоржийн Герман Улсад байхдаа Германы монголч эрдэмтэдтэй хамтран явуулсан эрдэм шинжилгээ, судалгааны ажлын ач холбогдол, үнэ цэнийг төдийлэн үл анзааран судалгаа тун бага хийгдэж байгаа билээ. Гэтэл Д. Нацагдоржийн Германд суралцсан зорилго, хийж бүтээсэн үйлс, амьдралыг (*Тэрээр Герман Улсад сурахаасаа өмнө Намын Төв Хорооны*

¹ МАХН-ын V Их хурал, V боть, Улаанбаатар, 1981 он, 222-р тал

² МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, *Монгол-Германы харилцааны данс-1-1д*, нугалбар № 10.

³ МАХН-ын V Их хурал, V боть, Улаанбаатар, 1981 он, 225-р тал.

⁴ "Ардын нам" сэтгүүл, Эрхэлсэн сайд Я. Цэвэл, "Олон сургуулиудын явуулага хөгжилтийн тухай" тайлан илтгэл, Улаанбаатар 1928 он, 44-69-р талд буй.

⁵ УТА. Фонд № 6, данс. 1, хадгаламжийн нэгж-140.

* Сергей Михайлович Вольф (- 1979)

Орос гаралтай. 1908 онд Петербургээс эцэг, эхийн хамт Англид цагаачлан ирсэн бөгөөд дараа нь Кембрижийн Их Сургуульд боловсрол эзэмшсэн байна. 1925-1929 онд Берлин хотод байсан "Монголын худалдаа, соёлын төлөөлөгчийн газар"-т орон тооны хэлмэрч, зөвлөх, Герман Улсын ерөнхий боловсролын болон тусгай мэргэжлийн сургуулиудад суралцаж байсан монгол хөвгүүд, охидын хүмүүжүүлэгч багшаар ажиллаж байжээ. Тэрээр ийнхүү монгол залууст туслахын зэрэгцээ Берлин хот дахь Английн мэтгэлцээний клубт лекц уншиж тухайн үеийн Монгол Улсын талаар тун ховорт тооцогдох, үнэн бодит мэдээллийг олон нийтэд хэвлэлээр танилцуулах ажлыг хийж байв. Тэрээр Берлин дэхь Монгол Улсын Худалдааны төлөөлөгчөөр ажиллаж байсан Б. Намсрайтай хамтран ажиллаж байжээ.

С. М. Вольф 1964 онд Монголд анх ирсэн бөгөөд мөн 1970 онд Олон Улсын Монголч эрдэмтдийн II их хуралд оролцож хоёр дахь удаагаа ирсэн байна. 1964-1979 онд өөд болох хүртлээ Англи-Монголын нийгэмлэгийн дэд даргаар ажиллаж байжээ. 1920-иад онд Герман, Францад суралцаж байсан монгол сурагчдын талаар эх сурвалжийн шинжтэй хэд хэдэн өгүүлэл бичиж хэвлүүлсэн.

⁶ Serge M. Wolff, "Mongol Delegation in Western Europe, /1925-1929/", in *Royal Central Asian Journal*, London, 1944.

Serge M. Wolff, "Mongolian Educational Venture in Western Europe /1926-1929/", in *Zentralasiatische Studien*, Bonn 5(1971), S. 249-250.

орлогч гишүүн зэрэг хариуцлагатай өндөр албан тушаалыг хашиж байсан юм.) бусад сурагчидтай харьцуулах аргагүй нь нэгэнт тодорхой юм.

Д.Нацагдорж Германд очсоныхоо дараа Тюринген /Thuringen/ дэх Виккерсдорф /Wickersdorf /-ын сургуулийн чөлөөт хотхонд байж, урьд нь монгол сурагчдад хичээл зааж байсан Даллер багшаар герман хэл, бичгийг анх заалгаж байгаад улмаар Санжаа нарын хамт мөн ондоо Берлин хотын гадаадын иргэдэд зориулсан Герман Хэл бичгийн сургууль /Аусландер/-т орж 1926 оны XI сараас 1927 оны VI сарыг хүртэл 7 сар гаруй суралцаад дараа нь Лайпциг хотод шилжин суралцсан байна¹. Д.Нацагдорж Аусландер институтэд суралцаж, герман хэлний мэдлэгээ сайжруулах зорилт тавьсан бөгөөд 1927 оны VI сарын 16-нд Б. Ишдорж багшид явуулсан нэгэн захидалдаа Аусландерт элсэн 2 курс суралцсан, саяхан дунд курст дэвшин орох шалгалт өгсөн тухайгаа бичсэн байдгаас үзвэл Д.Нацагдорж Берлин хотод 7 сарын хугацаанд байхдаа тус Хэлбичгийн институтэд суралцан төгсөж амжилгүйгээр Лайпциг хотод шилжсэн бөгөөд энэ тухай 1927 оны VI сарын 12-ны өдрийн захидалдаа “Би энэ завсар нэгэн санал оруулж буй бөгөөд эдүгээ нэгэнт Университетэд орж чадахгүй намрыг хүлээх тул энэ завсар энд байсны ашиг бага бөгөөд харин Берлинд очиж энэ Июнийн 16-наас Аусландер институтын нэг курс эхэлж курсээ 10-наа төгсөх ба мөн дараах курс нь Сентябрь сарын 5-наас эхлэн Октябрын 29 хүрч түүгээр бусад нэг зэрэг энэ хоёр курст явбаас энэхүү институтыг бүрэн дүүргээд болох ба хэл ч нилээд сайн болмой²” гэж санал оруулж байснаас тодорхой байна.

Д. Нацагдорж 1927 оны VI сарын эхээр Лайпцигт шилжсэнээр 1929 оны дунд үеийг хүртэл хоёр жил тус хотод байсан тул түүний Герман дахь амьдрал, эрдмийн үйл ажиллагаа нь Лайпциг хоттой салшгүй холбоотой байсан гэж үзэж болно. Д.Нацагдорж, Пагмадулам нарын Берлинээс Лайпциг хотод шилжин ирсэн шалтгааныг Э. Таубе “1925 оноос Лайпцигийн Их Сургуулийн Зүүн Азийн семинарыг удирдаж байсан Э. Хэниш түүнийг Лайпцигт авч ирсэн бололтой³” гэж үзсэн нь үндэслэлтэй юм. “Герман, Франц Улс дахь Монгол сурагчдын захиргаа”-тай хамтран ажиллаж байсан С. М. Вольф Д.Нацагдоржийг профессор Э. Хэништэй зуучлан танилцуулсан байна. Профессор Э. Хэниш, Д.Нацагдорж нарын эрдмийн хамтын ажиллагаа 1927 оны VI сарын дунд үеэс эхэлсэн бололтой. Энэ тухай Д.Нацагдорж Берлин хотод Б.Ишдорж багшид илгээсэн нэгэн захидалдаа: “...Бид энэ хотын дотор нэгэн байр олж суув. Мөнхүү 20-ны өдөр Хэнишийн Дорнодахины их сургуулийн монгол ангид очиж түүний ба бас монгол хэл үзэж бүхий сурагчдын хамт Алтангэрэл хэмээх судраас бага уншиж байгаад тараав. Нацаг, Лайпциг хот, 1927 он, 7 сарын 4⁴” гэж өгүүлсэн байдаг. Д.Нацагдорж Лайпциг хотод ирснийхээ дараа тус хотын Их Сургуулийн сэтгүүл зүйн салбарт суралцахаар бэлтгэж байсны зэрэгцээ Дорно дахины хэлбичгийн сургуульд зочны хувиар суралцаж, эрдэмтэн Э. Хэнишийн монгол хэл, бичиг, утга зохиолын талаархи судалгааны ажилд туслалцаж байжээ.

Уг сургуульд Д. Нацагдорж герман, орос, манж хэл, бичиг, түүх зэрэг хичээл заалгаж байв. Профессор Э.Хэнишээс Ж. Цэвээнд 1928 оны II сарын 1-нд явуулсан захидалдаа Д.Нацагдоржтой хамтран ажиллаж байгаа тухайгаа “...Бид амаар болон бичгээр монгол хэлнээс герман хэлээр орчуулга хийдэг юм. Тэрээр Шмидтийн толинд герман үгийн хэлхээс зохиож байгаа юм. Ийм маягаар нэг ёсны монгол-герман толь хийх зорилготой юм. Тольгүйгээр түүний хувьд ажиллах бэрхшээлтэй шүү дээ⁵” гэж бичиж байжээ. Зарим түүхэн баримтаас үзэхэд профессор Э.Хэнишийн судалгааны зарим ажлуудад (Тухайлбал Haenisch, E., “Altangerel (Suvarnaprabhasa-sutra. Westmongol) Die Westmongolische Fassung des Goldglanzsutra”, Nach einer Handschrift der Kgl. Bibliothek zu Kopenhagen. T. 1 Text. Leipzig: Asia Major 1929, VIII, 122 S.,) Д.Нацагдорж Германд суралцах хугацаандаа оролцсон байх магадлал байгаа ч тухайлан ямар судалгаанд оролцсон нь ихээхэн эргэлзээтэй бөгөөд тодруулан судлах ёстой асуудал билээ. Д.Нацагдорж Лайпцигт суралцаж байхдаа профессор Э.Хэнишийн урилгаар Лувсаннамжилын хамт Дорнод Азийн байгаль, угсаатны зүйн чиглэлээр судалгааны ажил явуулдаг Зүүн Азийн

¹ УТА. Фонд № 6, данс-1, хадгаламжийн нэгж-140

² Мөн тэнд, хуудасны дугаар-34, захидал № 28

³ Эрика Таубе, Д. Нацагдоржийн Лайпцигт байсан үеийн ул мөрийг мөшгин судласан минь, Ням гараг сонин, 1996. Таубе, Е., “Schwierige Spurensuche. Die Leipziger Studienjahre des Dichters Daschdordschijn Nacagdordsch”, in *Mongolische Notizen-Mitteilungen der Deutsch-Mongolischen Gesellschaft* 6(1997), S. 22-28.

⁴ УТА, Фонд № 6, данс. 1, хадгаламжийн нэгж-140, хуудасны дугаар-22, захидал № 19.

⁵ С. Идшинноров Жамсраны Цэвээн /түүвэр зохиол/, Улаанбаатар 1997.

клубын үйл ажиллагаанд оролцож байсан ажээ. 1927 он болоход түүний герман хэлний мэдлэг тун сайжирч хамт суралцаж байсан монгол нөхөддөө хэлмэрчлэн туслах, цаашилбал судалгаа шинжилгээний ажил хийх хэмжээнд хүрсэн байна. Учир нь түүний тэмдэглэлийн дэвтэртээ монгол бөөгийн дуудлагын 200 гаруй мөр шүлгийг герман хэлнээ хадан орчуулсан байсныг зарим судлаачид олж тогтоосон билээ.

Д.Нацагдорж профессор Э.Хэнишээс гадна төвд судлалын доцент Фридрих Веллертэй зохистой хамтран ажиллаж, тэдний гэр бүлийнхэн дотно харилцаатай байв. Ф.Веллер Д.Нацагдорж нар судалгааны чиглэлээр хамтран ажиллахын сацуу монгол, герман хэлийг сурахад харилцан бие биедээ тусалж байсан байна. Энэ тухай профессор Э.Хэнишийн дээр дурьдсан захидалд дурьдсан байдаг. Улмаар 1920-иод оны сүүлээр Д.Нацагдоржоос Ф. Веллерт Зөвлөлтийн Дорнодахин судлалын эрдэмтдийн бүтээлд олон арван шүүмж бичихэд тусалж байв. Д.Нацагдорж ийнхүү Дорнодахин хэлбичгийн сургуульд зочны хувиар суралцахын зэрэгцээ Лайпциг хотын дээд сургуулийн сэтгүүлчийн салбарт элсэж суралцахыг эрмэлзэж байлаа. Гэвч уг дээд сургуульд суралцахад дунд сургууль төгссөн гэрчилгээ, баримт дутагдалтай байсан учраас элсэн суралцаж чадахгүй байжээ. Учир нь Саксоны Академийн Сургалт, Мэргэжлийн Асуудал Эрхэлсэн Лавлагаа Мэдээллийн Албанаас 1928 оны VI сарын 12-нд гаргасан албан бичигт *"Гадаадын оюутан бүрийг элсүүлэхдээ түүний урьд нь төгссөн сургууль, мэдлэгийн төвшин германы элсэгчдийн төвшинтэй тохирч байгаа эсэхийг цаг тухайд нь шалган тогтоож байх шаардлагатай"*¹ гэж зааснаар дээд сургуульд элсэхэд өмнө нь төгссөн сургуулийн албан ёсны бичиг баримтыг шаардах болсон байна. Иймээс Д.Нацагдорж "Герман, Франц дахь Монгол сурагчдын захиргаа"-ны дарга Б. Ишдорж багшид хандаж Ардыг Гэгээрүүлэх яамнаас холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн илгээхэд туслахыг хүсч VI сарын 8, 12-нд бичсэн захидлууддаа тэмдэглэжээ.

Сурагч Д.Нацагдоржийн дээрх саналыг харгалзан эрхлэгч багш Б. Ишдорж 1927 оны VI сард Ардыг Гэгээрүүлэх яаманд уг хүсэлтийг уламжилсан боловч 1928 оны VIII сард тус яамнаас *"Бусад сурагчдын адил тэнцэх сургуульд сурваас зохино"* гэсэн хариуг өгсөн байна. Харин профессор Э.Хэнишийн *"Жамсрановоос өөрийн дэргэд бага сага сургууль, боловсролын ажил оролдож байсан хэмээх төдий үнэмлэх бичиг ирүүлвээс тэр сургуульд сонсогчийн хувиар явж болно"*² гэж зөвлөснийг дагаж дахин Б. Ишдорж багшаар уламжлуулснаар Ж.Цэвээн *"Д.Нацагдорж миний дэргэд сурч байсан. Эрдэм боловсролтой, цаашдаа судлал шинжилгээний ажил хийх чадвартай хүн"* гэсэн утга бүхий хувийн тодорхойлолт гарган өгсөн бөгөөд уг бичиг баримтыг Д.Нацагдорж 1928 оны сүүлээр хүлээн авсан бололтой.

Д.Нацагдоржийн Лайпцигийн Их Сургуулийн сэтгүүлийн ангид орж суралцаж байсан тухай мэдээ баримт байхгүй байгаа нь монголч эрдэмтэн Э.Таубегийн бичсэнчлэн тухайн үед Лайпцигийн Их Сургуулийн сэтгүүлчийн салбарын захирлаар ажиллаж байсан Эрих Эверт нь Э.Хэнишийн багын танил байсан тул Д.Нацагдорж Э.Хэнишээр зуучлуулан сонин, сэтгүүлийн ангид суралцаж чадсан гэдэг үнэний хувьтай болов уу? Учир нь доктор Э. Таубегийн олж тогтоосноор Лайпцигийн Их Сургуулийн архивт Д.Нацагдоржийн тус сургуульд албан ёсоор суралцаж байсан тухай баримт байхгүй байгаа нь тогтоогдсон тул тэрээр хувийн тохиролцооны дагуу суралцаж байсныг гэрчилж буй бололтой. Мөн энд тэмдэглэх ёстой нэгэн чухал зүйл нь Д.Нацагдорж Герман Улсад суралцаж байхдаа Судар Бичгийн Хүрээлэнтэй холбоотой ажиллаж зохих даалгавар, тэтгэмж хүлээн авч байснаар үл барам Судар Бичгийн хүрээлэнгийн дарга Ж.Цэвээн Д.Нацагдоржийг *"Хэл шинжлэгч, түүхч"* болгох зорилготойгоор итгэл хүлээлгэн суралцуулж байжээ.

Энэ тухай Ж.Цэвээн, Э.Хэниш нарын хооронд захидлаар харилцаж байсан захидлаас тодорхой харагддаг. 1928 оны II сарын 1-нд Э.Хэнишээс Ж.Цэвээнд бичсэн захидалд *"Ноён Нацагдоржийн хичээлийн талаар Таны бичсэн нь намайг их баярлуулав. Түүнд юу хэрэгтэй талаар таны бодол минийхтэй яг таагарч байна. Тухайлбал тэрээр бүхнээс түрүүнд герман хэлний ба Германы утга зохиолын сор дээжийн талаар нухацтай мэдлэг олж авах ёстой. Би багштай нь ийм санаачилгаар ярилцсан"*³ гэж бичсэн нь дээрхийг батлах жишээ юм. Д.Нацагдоржийн Герман Улсад суралцаж байхдаа хийж гүйцэтгэсэн нэгэн үр бүтээлтэй ажил нь

¹ Г. Дашням, *Д.Нацагдоржийн Лайпцигийн жилүүд, "Сэтгүүлч"* сэтгүүл, Улаанбаатар, 1989, № 3, 17-18-р тал

² С. Идшиноров, *Жамсраны Цэвээн, Түүвэр зохиол*, Улаанбаатар, 1997, 179-р тал

³ Мөн тэнд, 79-р тал.

түүний санаачилгаар Герман, Францад суралцаж байсан сурагчдын бичмэл "Монгол сэтгүүл"-ийг эрхлэн гаргаж байсан явдал юм. Д.Нацагдорж 1927 оны эцсээр уг сэтгүүлийг гаргах саналаа боловсруулж, сэтгүүлийн зорилго, агуулга, бүтцийг тодорхойлсон төлөвлөгөөг сийрүүлэн бичиж дарга Б. Ишдоржид танилцуулсан байна.

Д.Нацагдоржоос энэ тухайгаа "...Бидний эндэх сурагч нараас өөрийн үндэсний эрх чөлөөний тухай ба эрдэм боловсролын тухай урагш дэвших зүйлүүдийг монгол хэл дээрээ бичиж сар бүр хэвлэн сурагчдын сэтгүүл болгон гаргаж Монгол Улс ба жич бусад гадаад газар бүхий монгол сурагч нарт тархаан явуулж байваас бидний боловсролын явдалд тус нэмэр болох болов уу хэмээх тул зохих газар уламжлан зөвшөөрлийг авч өгмүү¹" хэмээн бичсэнийг "Герман, Франц дахь Монгол сурагчдын захиргаа"-наас дэмжин сайшааж улмаар тус захиргаанаас 1927 оны XI сарын 15-ны өдөр Ардыг Гэгээрүүлэх яамнаа явуулсан 6 тоот албан бичигт "...Сурагч Нацагдоржийн ийнхүү санал гаргасан нь мөн ч эрдэм боловсролын замд дэвших хэмээсэн бодлого болох агаад алин бүрд харшлах зүйлгүй мэт тул уг сийрүүлэлтийг бичсэний хойно хэвээр сийрүүлэн үүнийг Ардыг Гэгээрүүлэх яамнаа өргөн мэдүүлээд олдвоос байцаан толилж дээр дурдсан саналын ёсоор зөвшөөрлийг олгох ажаамуу хэмээн үүний тул эрэв²" гэж дурьдсан байна.

Улмаар 1928 оны IX сард сэтгүүлийн анхны дугаар хэвлэгдэн гарсан бөгөөд уг сэтгүүл нь 14х25 хэмжээтэй, 21 хуудастай байжээ. Хэдийгээр тухайн үед сурагчдын сэтгүүлийг сар бүр хэвлэн гаргаж байхаар төлөвлөж байсан боловч одоогоор энэ сэтгүүлийн хоёр дугаар л Герман, Англи улсуудаас олоод байна. Сурагчид сэтгүүлийнхээ зорилгыг "...Бидний сурагч нарын бодлого болбоос Европын аль чухал сайныг нь олж сураад дараа харъяат улс төр, ард түмэндээ тус хүргэсүгэй хэмээсэн учир манай сэтгүүл болбоос үүнийг гүйцэтгэхэд дөхөм болсугай" гэж тодорхойлсон байна. Сурагчдын сэтгүүлийн нийтлэл нь "нэгдүгээрт, монгол сурагч нарт үндэсний түүх шастир, хэл бичгийг умартуулахгүй байх, хоёрдугаарт, Монголын улс төрийн байдал ба олон улсын байдал, урагш дэвшиж бүхий зэргийг танилцуулах, гуравдугаарт, гадаад, дотоодын сургуулийн сурагчдын хооронд харилцаа холбоо тогтооход оршино³" гэж заасан байна.

Д.Нацагдорж сэтгүүлийн эхний дугаарт Элдэв-Очир гэсэн нууц нэрээр /Д.Нацагдорж гэсэн нэрийн төвд орчуулга/ "Манай үе ба манай үүрэг", "Цаг, цаг, цаг", "Манай сэтгүүлийн зорилго" зэрэг өгүүллэгийг нийтлүүлсэн байна. Дээрх өгүүллүүдэд "цаг үеийнхээ шаардлага, хариуцлагыг ухамсарлан эрдэм боловсролд мэрийн шамдаж, эх орноо хөгжүүлэн бадраах" зэргээр гадаадад суралцаж буй залуучуудад "тэдний энэ үйл хэрэг нь хувийн хэрэг биш, эх орны хөгжил цэцэглэлтийн шаардлагын үүднээс гарсан нийгэм-улс төрийн учир холбогдолтой зүйл юм гэдгийг ухуулж улмаар гадаад улсуудад суралцагсдыг эх орон, ард түмнийхээ гүн их итгэл, найдварыг хүлээсэн тул авъяас билэгээ гаргаж эрдэм номд шамдах" эрхэм үүрэгтэйг тайлбарлан бичсэн байна. Мөн уг сэтгүүлд дарга Б. Ишдорж "Сургуулийн тухай", Парис хотод ажиллаж, суралцаж байсан Мэргэн хэмээх Гомбожав "Ямагт харилцаж байвал тусгай" зэрэг өгүүлэлүүд нийтлүүлжээ. Сэтгүүлийн дараагийн дугаар 1928 оны XI сард хэвлэгдсэн ба энэ дугаарт "Нутгийн сонин", "Зохион байгуулагчид сануулах нь", "Сурах ба боловсрох", "Спорт гэж юу вэ?", "Герман Улсын байдлаас" зэрэг өгүүлүүд нийтлэгдэж байв. Сурагчдын сэтгүүлийг Герман, Франц, ЗХУ-д суралцаж байсан сурагчдад тараан илгээж байсан бөгөөд эдгээр сурагчдын хоорондын харилцааг сайжруулах үүднээс Герман, Францын сурагчдын оршин сууж, суралцаж байсан хот, сургуулиудын хаягийг жагсаан нийтэлсэн байна⁴. Мөн Москва дахь БНМАУ-ын Бүрэн Эрхэт төлөөлөгчийн газар, элчин сайд Гүрсэдэд "Герман, Франц дахь Монгол сурагчдын захиргаа"-наас сурагчдын сэтгүүлийн нэг хувийг явуулж байсан баримт байдаг.

Энэ тухай дарга Б. Ишдоржоос элчин сайд Гүрсэдэд бичсэн захидалдаа "... Жич, манай эндэх сурагчдаас сурагчдын сэтгүүл гаргая хэмээн санал гаргасныг уламжлан зохих газраас зөвшөөрөл олгосон тул сая тус сэтгүүлийг үүсгэн нэгдүгээр дэвтэр дарамлан гаргасан тул нэг хувийг өргөн толилуулав. Бас Ленинград ба Москвагийн сурагчдад нэгжээд хувийг

¹ УТА, Фонд № 6, данс.1, хадгаламжийн нэгж-153 хуудасны дугаар-51.

² Мөн тэнд.

³ Д. Цэдэв, Германд гарч байсан Монгол сэтгүүл, "Утга зохиол-урлаг" сонин", Улаанбаатар, 1967. XI. 13.

⁴ Д. Цэдэв, Германд гарч байсан Монгол сэтгүүл, "Утга зохиол-урлаг" сонин", Улаанбаатар, 1967. XI. 13.

хүргүүлснийг цааш уламжлахыг гуйсугай¹” гэж дурдсанаас тодорхой байна. Уг сэтгүүлд нийтлэх материалыг эрхлэгч багш, сурагчид хамтран бэлтгэж тухайн үеийн тогтмол хэвлэл болох “Үнэн” сониноос материалыг авч ашигладаг байжээ. Д.Нацагдоржийн санаачилгаар эрхлэн гаргаж байсан сурагчдын монгол сэтгүүл нь зохих газраас ихээхэн дэмжлэг хүлээж байсан тул “Герман, Франц Улс дахь Монгол сурагчидын захиргаа”-ны дарга Б. Ишдорж дээрээс өгсөн зааврын дагуу Германы Вандерер (Wanderer) үйлдвэрт анхны монгол үсгийн машиныг захиалан хийлгэж Монгол руу 100 ширхэгийг илгээсэн ба өөрөө нэгийг авч үлдээд захиргаанаас оюутнуудтайгаа хамтран эрхилж байсан “Сурагчдын монгол сэтгүүл”-ийн эхийг бичиж, хувилах ажлыг гүйцэтгэж байжээ².

Юутай ч уг сэтгүүл хэвлэгдэн гарснаар Герман, Франц болон ЗХУ-д суралцаж байсан монголын суралцагчдын сурах идэвх дээшлэх, хоорондын харилцаа, холбоо сайжрах, улмаар сурч боловсрох үүрэг хариуцлагаа ухамсарлан ойлгох зэрэгт ихээхэн ач холбогдолтой зүйл болсон нь дамжиггүй. Үүнд Д.Нацагдоржийн гүйцэтгэсэн үүрэг их байсан нь тодорхой. Д.Нацагдорж 1927 оны VI сараас 1929 оны VI сар хүртэл Герман Улсын Лайпциг хотод суралцаж байсан жилүүддээ Германы сонгодог уран зохиолоос орчуулж байсан төдийгүй Герман Улсад байхдаа “*Майн нэгнийг хөрөнгөтний оронд үзсэн минь*” зэрэг хэд хэдэн өгүүлэл бичсэн байна. Уг өгүүллийг 1928 оны V сарын 1-нд Берлин, Гамбург, Лайпциг, Штутгарт, Мюнхен, Эссен зэрэг хотуудад болсон хөдөлмөрчдийн жагсаалыг үзсэн сэтгэгдэлдээ үндэслэн бичсэн байна.

Эрдэмтэн профессор Э.Хэниш 1928 оны зун Хятад, Монголд хэл, ном судар, угсаатны зүйн судалгаа хийгээд буцахдаа “*Монголын Нууц Товчоо*”-ны бичмэл эхийг Герман Улсад аваачсан бөгөөд улмаар “*Монголын Нууц Товчоо*”-ны хэвлэмэл эхийг монгол хэлнээ сэргээн хөрвүүлэх ажилд Д.Нацагдорж Герман Улсаас эргэн татагдах хүртлээ оролцож байсан бололтой³. Ийнхүү Д.Нацагдорж Лайпциг хотод суралцаж байхдаа Монгол, Герман хоёр улсын хооронд шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний найрсаг хэлхээ холбоо бий болгохыг зорьж байсан төдийгүй Э.Таубе Д.Нацагдорж, Э.Хэниш нарын хамтын ажиллагаагаар Монгол, Германы эрдэмтдийн харилцаа, холбооны эхлэл тавигдсан гэж дүгнэсэнд бүрэн тал өгч болох юм.

Д. Нацагдорж тухайн үеийн Германы монгол судлалын төв Лайпцигын Их Сургуульд очиж ажилласнаар хожмын олон арван судлаачдын үр бүтээлтэй хамтын ажиллагааны зам мөрийн эхлэлийг гаргасан анхны судлаач болсон байна.

Харин Д.Нацагдоржийн эхнэр Пагмадуламын хувьд Берлин хотод байхдаа ямар нэгэн сургуульд суралцаж чадаагүй байсан бололтой. Харин Лайпциг хотод ирсний дараа тус хотын Бүсгүйчүүд (Охидын)-ийн сургууль /*Hoherе Tochterп (Madchen) schule/* -д суралцахаар бэлдэж байв. Энэ тухай Д.Нацагдоржоос 1927 оны IX сарын 2-нд Б. Ишдорж багшид бичсэн захидалд “...Пагмыг мөнхүү хотын “Бүсгүйчүүдийн дээд сургууль” (Д.Нацагдорж ингэж бичжээ. Р. Т) хэмээхэд оруулах санаатай ба үүний урьд мөнхүү сургуулийн программыг авч үзэх нь зүгээр сайн ба нэг эрхлэгч эхнэрээс асуулгасан нь болмоор байсан тул ая зүйг эрээд болох байх⁴” гэж бичсэн нь үүний нотолгоо юм. Пагмадулам дээд сургуульд орж суралцах эрмэлзлэл их байсан ч дунд сургууль төгссөн бичиг баримт байгаагүй учир мөн олон хүндрэлтэй асуудал тулгарч байжээ. Иймээс Пагмадулам Лайпцигт очсоныхоо дараа хувийн дунд сургуульд суралцаж, багш хөлслөн герман хэл заалгаж байсан нь түүний илгээж байсан захидлуудаас тодорхой харагддаг. Улмаар 1929 оны хавраас Эмнэлэгийн лабораторийн сургуульд орохоор завдаж байгаад Герман Улсаас эргэн татагдсан байна.

Энэ тухайгаа хожим нь 1929 оны VIII сарын 26-нд Герман Улсад үргэлжлүүлэн суралцуулахыг хүсч Ардыг Гэгээрүүлэх яаманд өгсөн өргөдөлдөө Пагмадулам тодорхой өгүүлсэн байдаг ба энд дурдахдаа “...Миний бие 2 жил илүү Германд сургуульд сурахад хэл бичгийг төсөөлж басхүү Бүсгүйчүүдийн тусгай сургуульд явж байсан бөгөөд тусгайлан цус зэргийг шинжих зэрэг лабораторийн ажлыг үйлдэх ба эмчийн дэргэд туслах, ариун цэврийг хамгаалах явдлыг гүйцэтгэх ийм нэгэн эмнэлгийн сургуульд одохыг завдан байсан⁵” гэж

¹ УТА, Фонд № 6, данс 1, хадгаламжийн нэгж-178 хуудасны дугаар-40.

² Мөн тэнд, 275-р тал.

³ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, Монгол-Германы харилцааны данс-1-1д, нугалбар № 21.

⁴ УТА, Фонд № 6, данс 1, хадгаламжийн нэгж-140 хуудасны дугаар-46.

⁵ Л. Балдан, Д.Нацагдоржийн монгол гэргий нь Амгаланбаатар хотын нэгэн мужааны охин өгүүлэл, Ганунда сонин, Улаанбаатар, 2001. XI. 15.

дурдсанаас тодорхой байна. Ийнхүү Пагдадулам нөхөр Д. Нацагдоржийн хамт түүний бичсэнээр "Бүсгүйчүүдийг хоцрогдсон байдлаас хагацуулж тус улсын боловсролын явдлыг хөгжүүлэх хэрэгт нөхөөр болохоор" идэвхийлэн суралцаж байсан ажээ.

3. Герман Улс дахь бусад сурагчдын боловсрол, сургалтын байдал

Айзенах хотын автомашины Dixi үйлдвэрт 1927 оны эхээс Базарням, Лувсан нарын сурагчид суралцаж эхэлсэн юм. Тэд тус үйлдвэрт автомашин, механикийн чиглэлээр суралцаж байжээ. Түүхэн баримтаас үзвэл сурагч Базарням Герман Улсад суралцаж байхдаа Айзенах хотын Dixi үйлдвэрийн хичээл, дадлагын ажилд идэвхтэй оролцож байжээ. Гэвч энэ нь түүний биеийн байдалд сөргөөр нөлөөлж байсан юм. Автомеханикийн чиглэлээр монгол сурагчдыг сургаж мэргэжилтэн бэлтгэхэд тухайн үед манай улсын Засгийн газраас өндөр ач холбогдол өгч байсан юм. Энэ үүднээс Сампилион тэргүүтэй Монголын Засгийн газрын төлөөлөгчид 1925 оны намраас энэ талын зохих хэлэлцээр хийж эдийн засаг, худалдааны талаар Герман Улстай зохих тохиролцоонд хүрч байсан зэргээс үндэслэн Айзенах хот дахь Базарням, Лувсан нарын суралцаж байсан мэргэжил, тухайн үед манай улсад нэн шаардлагатай байсан боловсон хүчний хэрэгцээг хангахад чиглэгдсэн нэгэн чухал алхам байжээ.

Берлин хотын Ханноверийн ойролцоо Лецлинген хотод Лувсанцэнд, Цэвэг, Сурмаажав, Юмхүү нарын 4 сурагч гар үйлдвэрлэлийн хамтлагт дадлага хийж ажиллахаас гадна Ерөнхий боловсролын сургуульд суралцаж байсан байна. Лецлинген хот дахь эдгээр сурагчдын тухай баримт нь тэдний "Герман, Франц Улс дахь Монгол сурагчдын захиргаа"-ны дарга Б. Ишдоржид илгээж байсан захидалд тодорхой тэмдэглэгдэн үлджээ. Мөн Герман Улсын нийслэл Берлин хотод төвлөрч байсан дээрх захиргаатай хамтран ажиллаж байсан С. Вольф Лецлингений монгол сурагчдын байдалтай танилцах ажлаар дарга Б. Ишдоржийн хамт хоёр ч удаа тэдгээр сурагчидтай уулзаж байсан тухайгаа хожим 1964 оны хавар Лондон хотноо бичсэн дурсамж өгүүлэлдээ дэлгэрэнгүй өгүүлжээ. 1927 оны II сарын 3-ны өдөр сурагч Лувсанцэндээс "Герман, Франц Улс дахь Монгол сурагчдын захиргаа"-нд илгээсэн захидалдаа бичсэнээс үзвэл Лецлингений монгол сурагчид нь ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрийн дагуу суралцаж герман хэлбичиг, математик, уран зохиол, дуу хөгжим, түүх, биеийн тамир гэх зэрэг ерөнхий хичээлүүдийг үздэг байжээ.

Лецлинген хотын сургуульд суралцаж байсан дөрвөн сурагч дотроос сурагч Цэвэг нөхдөөсөө нэг анги дээр суралцаж байв. Энэ тухай сурагч Юмхүүгийн 1927 оны VI сарын 27-ны өдөр бичсэн захидалд ". . . Бид нар энд бүгд мэнд сайн байгаагаас ангид нөхөр Цэвэг бид нараас урьд нэг анги дээш дэвшин ороод түүний хойно бид нар мөн Цэвэгийн ангид ороод дөрвүүлээ нэг ангид сууж сургууль заалган байна. Бид нар энд сургууль дээр их байна. Сургуулиа хичээн чармайж үзсээр байна¹" гэж бичжээ. Мөн Лувсанцэнд, Сурмаажав, Юмхүү нарын сурагчид 1927 оны VI сарын дундуур анги дэвшиж Цэвэгийн хамт дөрвүүл хамт суралцаж байжээ. Лецлингений монгол сурагчид VII сарын 19-нөөс эхлэн хичээлийн зав чөлөөгөөр нэг цагийн хугацаатайгаар герман хэл, бичиг заалгаж хэлний мэдлэгээ сайжруулахыг зорьж байжээ. Тэд чөлөөт цагаа Герман орноор аяллаар явах, жүжиг үзэх, хөгжим сурах, биеийн тамираар хичээллэх зэргээр өнгөрүүлдэг байжээ. Лувсанцэнд /1927 оны VIII сарын 30/, Сурмаажав /1927 оны IX сарын 13/ нарын захидлуудаас авч үзвэл долоо хоногийн хугацаатай Герман орноор аяллаар явж, үүндээ нийт 120 орчим маркийг зарцуулж байжээ. Гэвч сүүлд сурагч Сурмаажав Виккерсдорфын сургуульд, сурагч Лувсанцэнд А.Е.С. цахилгааны сургуульд шилжин суралцах болжээ. Ийнхүү Лувсанцэнд, Цэвэг, Сурмаажав, Юмхүү нарын сурагчид 1927 оны эхнээс 1929 оны зуныг хүртэл Герман Улсад суралцсан байна.

1927 оны II сард Содном /III/, Сумади, Юмбүү нарын гурван сурагчийг Фронаугаас Фрайберг хотын арьс шир боловсруулах сургууль /Deutsch Gerberschule in Freiberg/-д суралцуулахаар илгээсэн байна. Содном /III/, Сумади, Юмбүү нар 1909 онд төрсөн үе тэнгийн сурагчид байжээ. Тэд 1928 оны IV сар хүртэл тус сургуульд дадлагын ажил хийж байгаад дараа нь жинхэнэ сурагчид болж чадсан байна. Фрайбергийн сурагчид сургуульдаа албан ёсоор элсэн суралцахад эхний үед хэлний бэрхшээлтэй тулгарч байсан юм. С. Вольф хожим Фрайбергийн арьс, шир боловсруулах сургуулийн монгол сурагчдын сурч, дадлагажиж байсан ажлыг ихээхэн

¹ УТА, Фонд № 6, данс.1, хадгаламжийн нэгж-140, хуудасны дугаар-33

сонирхолтой, бахдам зүйл байсан гэж өгүүлэлдээ тэмдэглэсэн нь бий. Арьс, шир боловсруулах ажилд хэрхэн суралцаж байгаа тухайгаа сурагч Сумадигаас 1927 оны II сарын 30-ны өдөр бичсэн захидалдаа "...энэ хэр биднүүдийн арьсны ажлыг төдий л муухай хэлдэггүй... Гэвч хэл мэдэх хүнээс асуух зүйл эрх биш буй гэсэн атугай ч ихэвчлэн өөрийн мэдсэнээр хийж чадах буй за, биднийг энэ хэр сурваас зохих зүйл оролдуулан буй"¹ гэж бичсэн байна. Хэдийгээр Фрайберг хотод арьс шир боловсруулах технологид суралцаж байсан дээрх дөрвөн сурагчид холбогдох баримт ховор байгаа боловч тэд 1929 оны дунд үе хүртэл тус хотноо суралцаар байжээ.

Мөн Сурагч Гомбожав, Сумъяа нар 1926 оны X сараас эхлэн Котбус хот дахь Пруссийн Нэхмэлийн Төв сургуульд үйлдвэрлэлийн дадлагын ажил хийх байв. Сурагч Гомбожав 1926. X-1927. X сар хүртэл тус сургуульд дагалдан суралцагчаар ажиллаж дадлага хийхийн зэрэгцээ герман хэл, бичигт сайн суралцаж байсан тул дарга Б. Ишдоржийн санаачлагаар 1927 оны IX сард Германы нэхмэлийн үйлдвэрлэлийн томоохон төвүүдийн нэг болох Хемьниц (Chemnitz)-ээс холгүй орших Саксон мужийн Рейхенбахын сургуульд шилжин суралцах болсон байна. Харин сурагч Сумъяа нь герман хэл, бичигт төдийлэн сайн суралцаж чадахгүй байсан тул Котбус дахь сургуульдаа дадлагынхаа ажлыг хийсээр байжээ. Иймээс дарга Б. Ишдоржоос 1927 оны VI сард сурагч Сумъяад бичсэн захидалдаа түүнийг герман хэл, бичиг болон бусад зааж буй хичээлүүдэд идэвхтэй хичээн суралцахыг даалгаж байв².

Герман дахь монгол сурагчдын томоохон бүрэлдэхүүн Герман Улсын өмнөд нутгийн Залфельд хотын ойролцоо Тюрингений ойд байрлах, 1906 онд байгуулагдсан Виккерсдорфын сургуульд суралцаж байсан юм. Виккерсдорфын ерөнхий боловсролын сургуульд Бадарчин, Гомбо, Намдаг, Намхайцэрэн, Т. Нацагдорж, Сэдэд, Цэвээн, Батсүх, Халаа, Цэрэнханд нарын 14-17 насны 10 монгол сурагч тус бүр өөр өөр ангид хуваарилагдан суралцаж байжээ. 1926 оны XII сарын 29-ний өдөр Виккерсдорфын сургуульд монгол сурагчдыг элсүүлэх саналыг тавьсан бөгөөд улмаар 1927 оны XI сарын 15-ны өдрөөс монгол сурагчдын бүрэлдэхүүнийг элсүүлэн суралцуулах болсон гэж С. М. Вольф бичсэн байдаг. Гэвч өдгөө бидэнд байгаа зарим түүхийн эх сурвалжаас үзвэл монгол хүүхдүүд Виккерсдорфын сургуульд өөрсдийн сонирхолоороо элсэх суралцсан байж болох юм. Виккерсдорфын монгол сурагчид 1927 оны II сарын 16-ны өдрийн захидалдаа бичсэнчлэн "Уул сургуульдаа ихээхэн хичээн хэр чинээгээр зүтгэхийг ихэд шамдан суралцаж" байжээ. Виккерсдорфын сургуулийн сурагчдын тухайн үеийн хичээл сургуулийн байдал, амьдрал ахуйн тухай "Герман, Франц Улс дахь Монгол сурагчдын захиргаа"-нд илгээсэн захидал бичиг, тус захиргааны тайлан мэдээ зэрэгт тодорхой тэмдэглэгджээ. 1927 оны II сарын 10-нд дарга Ишдоржид Виккерсдорфын сурагчдаас бичсэн захидалд "...Өчүүхэн шавь нар бидэн бүгдээр энэхүү Виккерсдорф хэмээх сургуульнаа ирээд Тантай гар барилцан салснаас хойш уул сургуулийн байдал шавь нар бүгдтэй хэвийн мэт уул сургуулийн ба заадаг зүйлийг үзсээр сууж амой хэмээхээс гадна бид цөм зарим өдөрт дөрөв ба нэг хоёрын хэр сургууль хийдэг болой . . . Мөн герман шавь наруудаас бидэнд тусгайлан багш гарч онцлон заадаг нь герман хэл, бутархай тоо хоёрыг өдөрт нэг нэгээр ээлжлэн нэг цагийн хэр заадаг болой"³ гэж бичсэн байдаг.

Сурагчдын захидалд бичсэнээр Виккерсдорфын монгол сурагчид эхний үед хэлний хүндрэлээс шалтгаалан суралцахад элдэв бэрхшээл гарч байжээ. Энэ тухай 1927 оны X сарын 27-ны өдрөөс эхлэн Германд суралцаж байгаа нийт сурагчдынхаа байдалтай биечлэн танилцсаны дараа Б. Ишдорж багшийн бичсэн тайланд "... Виккерсдорф хэмээх газар бүхий бэлтгэлийн сургуулийн 10 хүүхдүүд цөм бага насны хүүхдүүд тэндэх Виккерсдорф хэмээх газар болбоос хөдөө тал хээр сайтай тул манай хүүхдүүдийн бие тамир ихэд сайны дор байдал төлөв нь бие сайн бөгөөд гагцхүү зарим нь герман хэлд сайн дойч зэрэг бусдын хамтаар суралцаад эрдэмд хоцрогдох зүйл буй хэмээснийг бидний багш лугаа хэлэлцэн хэл сургууль үйлдэхэд сайн мэтээр ялгаруулан анги болгож бас хөгжмийн сургууль оролдож буй тул тэдэнд 2 хуур авч өгөхөөр тогтов"⁴ гэжээ.

¹ УТА, Фонд № 6, данс.1, хадгаламжийн нэгж-140 хуудасны дугаар-71.

² УТА, Фонд № 6, данс.1, хадгаламжийн нэгж-153 хуудасны дугаар-57.

³ УТА, Фонд № 6, данс.1, хадгаламжийн нэгж-140 хуудасны дугаар-5, захидал № 4.

⁴ Мөн тэнд.

Ийнхүү Виккерсдорфын сургуулийн сурагчдын ахуй байдал, судалж байсан хичээл зэргийг "Герман, Франц улс дахь Монгол сурагчдын захиргаа"-наас байнга анхааран үзэж, зохистой дэмжлэгийг үзүүлдэг байжээ. Виккерсдорфын сурагчдын 1927 оны VI сарын 29-ний өдрийн захидалд бичсэнээр монгол сурагчдын сурлагын төвшин, онцлогийг харгалзан тусгай хөтөлбөрөөр нэг анги болгон хичээл заах болсон нь тэдний хичээл, сурлагын чанарт эерэгээр нөлөөлсөн шийдвэр болжээ. Виккерсдорфын сурагчид 1927 оны дундуур Герман орноор сургуулийн багш, сурагчдын хамт хоёр долоо хоног аялсан байна. Харин ямар газруудаар, хэрхэн аялсан тухай баримт олдохгүй байна. Юутай ч Виккерсдорфын монгол сурагчид суралцах хугацаандаа герман сурагчидтай танилцан нөхөрлөх болсон нь тэдний хичээл сургууль, хэлний мэдлэгээ сайжруулах, цаашилбал тус орныг илүү сайн танин мэдэхэд дөхөм үзүүлсэн нь дамжиггүй юм. Ялангуяа сурагч Намхайцэрэн, Цэрэнханд нар герман сурагчдын хамт Лайпциг зэрэг хотуудаар аялж байсан нь тэдний захидлуудаас тодорхой мэдэгддэг. Виккерсдорфын сургуульд монгол сурагчид 1927-1929 оны сүүл хүртэл суралцаж байжээ. Энэ хугацаанд Халаа зэрэг монголын зарим сурагчид герман хэлийг тун сайн сурсан байна. Виккерсдорфын сурагчид хэдийгээр ихэвчлэн насаар бага хүүхдүүд байсан боловч Германд суралцаж байхдаа бие биендээ ихээхэн анхаарал тавьж, нэгдмэл санаа зорилготойгоор суралцаж байсан нь тэдний захидлаас тодорхой харагдаж байна.

Үүнээс гадна Пруссийн Боловсролын Яамтай хийсэн хэлэлцээрийн дагуу Берлин хотын Лихтерфельде дүүрэгт орших Улсын Сургалтын байгууллагын дунд сургуульд сурагч Бавуу, Доржсүрэн, Наваан-Юндэн, Пүрэвдорж, Содном нар суралцаж байв. Эдгээр сурагчид Берлин хотод ирснийхээ дараа Лихтерфельде дүүрэгт орших профессор Леонордагийн гэрт амьдарч байжээ. Лихтерфельдийн сурагчид Берлин хотноо төвлөрч байсан "Герман, Франц дахь Монгол сурагчдын захиргаа"-тай байнга холбоотой байж багш Буддарь, Б. Ишдорж нартай биеэр очиж уулзах, захидал илгээх зэргээр харилцаж байжээ. 1927 оны VII сарын 20-ны өдөр багш дээрхи сурагчдаас Б. Ишдорж багшдаа явуулсан нэгэн захидалдаа "... Энэ хэр бид нар энд мэнд амар бөгөөд аливаад ахуй зохисой амой. Бид нар энэхүү өнгөрсөн сайн өдөр Пабрикийн хамт Швецэд очихуй бүхэл өдөр байж мөн оройдоо эргэж ирэв¹" гэж дурьдсанаас үзвэл эдгээр сурагчид хичээл сургуулийн чөлөө цагаараа гадаадын зарим улсуудад аялж, дээрх улсуудын байдалтай танилцаж байсан байна. Берлины сурагчид герман хэл, бичигт тун сайн суралцаж байсан юм.

Удалгүй Наваан-Юндэн, Пүрэвдорж нарыг Берлины Лихтерфельдийн сургуулиас Потсдам хотод шилжүүлсэн бөгөөд тэд Потсдам хотод Пруссийн армийн офицер хошууч Блокийн гэрт амьдрах болсон байна. С. Вольфийн бичсэнээс үзвэл Наваан-Юндэн, Пүрэвдорж нар Потсдам хотод байхдаа хошууч Блокийн нилээд хатуу шаардлагатай орчинд амьдарч, сурч байсан байна. Учир нь, хошууч Блок тэднийг жинхэнэ цэргийн хүний хүмүүжлээр сургаж хүмүүжүүлж байжээ². Наваан-Юндэн, Пүрэвдорж нар Потсдам хотод сурч байхдаа хийж, бүтээж байсан зүйлсийн тухай мэдээлэл нь 1927 оны V сарын 10-нд Б. Ишдорж багшид Наваан-Юндэнгээс илгээсэн захидалд тусгалаа олжээ. Захидалд өгүүлснээр "... Толилуулах нь, өчүүхэн Наваан-Юндэн би үүний урьд дэлхийн байдлын зураг хэвлүүлэхийн тухайд монгол үсгээр бичихийг хамт элбэлцэж уг хэргийг төгсүүлэхэд ойртуулсан бөгөөд эдүгээ тэрхүү хэрэг төдий л сайн бус гүйцэлдсэн хэмээвээс үнэхээр гүйцэтгэх, бүтээхийг чармайн оролдон зүтгэсний буюу, ер нь сайд Батхааны энд бүхий үсэг эхлэн дарга, толгой нарын гарт тэрхүү зураг бичгийг удаа дараа цөөн бус бичиж гүйцэтгэсэн болох учрыг хамтад мэдүүлж өчүүхэн хүн байдлыг илэрхийлж³" гэж бичсэнээс илэрхий харагдаж байна.

Дээр дурьдсан газрын зураг хийх үйл ажиллагаанд Герман Улсад суралцаж байсан сурагчид, цаашилбал Ардыг Гэгээрүүлэх яамнаас ихээхэн анхаарал, хүч зарж байсан онцгой зүйл байсан бөгөөд уг үйл хэрэгт сурагч Наваан-Юндэн оролцож байсан түүхэн баримт нь энэ юм. Бусад сурагчдын тухай дэлгэрэнгүй баримт төдийлөн ховор байгаа боловч Берлин хотын Лихтерфельдийн сурагчид хичээл сургалт, үйлдвэр, заводод хийж байсан тусгай дадлагын ажилдаа зохистой шамдан суралцацгааж байжээ.

¹ УТА. Фонд № 6. данс-1, хадгаламжийн нэгж-140, хуудасны дугаар-41.

² Serge M. Wolff, *дурьдсан өгүүлэл*, 264-265.

³ УТА. Фонд № 6. данс-1, хадгаламжийн нэгж-140, хуудасны дугаар-21, захидал № 18.

Берлин хотод суралцаж байсан сурагч Санжаа Берлин хотын Бранденбургийн ойролцоо Ораниенбургийн "Хөдөө аж ахуйн сургалтын байгууллага" /Landwirtschaftliche Lehranstalt in Oranienburg Luisenhof/ -д суралцаж байв. С.Вольфын өгүүлэлд бичсэнээр тэрээр дээрх сургуульд суралцаж байхдаа герман хэлийг чамгүй сурчээ. Б. Ишдорж багшийн тайланд өгүүлснээр Санжааг "... Ямар нэгэн хөдөөгийн тариалан бүхий айлын газар сууж хагас жил буюу нэг жил оролдоос эрх биш тариалангийн зүйлийн юмыг нилээд мэдэх хүн болох болов уу хэмээн итгэж буй. Тэрхүү сургууль болбоос цөөхөн сурагчтай бөгөөд заах зүйлүүд нь нилээд оновчтой, бас сурагч нар нь мөнхүү сургуулийн дэргэд үргэлж суух бөгөөд суух орон сав нь ихэд зохистой баймой. Мөн манай Санжааг сургуулийн газар суулгах болсон ба төлбөр нь хямдхан болой. Санжаа ирсээр төдий удсангүй боловч угаас сэргэлэн хүн тул ярилцах хэлийг нилээд мэдэж төсөөлсөн ба эдүгээ Германы залуучууд лугаа хамт сууж ярилцахууд энэ хэр бэрхтэй байвч ер нь гайгүй бололтой хэмээн Санжаа өөрөө өгүүлэн буй. Санжаа болбоос 10 сарын 10-ны өдөр эхлэн сургуульдаа орсон болой"¹ гэж өгүүлсэн байна.

Эндээс үзэхэд Санжаа нь тус сургуульд ирснээс хойш газар тариалангийн чиглэлээр суралцаж ерөнхий эрдмийн хичээл, герман хэл, бичиг, тоо бодлого, түмэн бодис зэргийг нэгдүгээр ангидаа судалж байжээ. "Хөдөө Аж Ахуйн Сургалтын Байгууллага" /Landwirtschaftliche Lehranstalt in Oranienburg Luisenhof/ нь 2, 3-р ангид газар тариалангийн үндсэн ухагдахууныг заадаг, 4-р ангид газар тариалангийн практик ажлыг сургадаг ажээ. Тус сургуульд суралцахаас өмнө Санжаа нь "Аунхадори"-д 3-р анги төгссөн бөгөөд өөрөө Фрайбергийн автомашины сургуульд явах хүсэлтэй байсан боловч тухайн үед Монголд газар тариалангийн мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байсан шалтгааны улмаас Б. Ишдорж багшийн зөвлөсний дагуу тус сургуульд элсэн суралцах болсон байна. С. М. Вольфын өгүүлэлд Санжаагийн тухай тодорхой өгүүлсэн байдаг бөгөөд түүний нэг захидлыг нийтлэсэн байна. 1928 оны IX сарын 18-ний өдөр Б.Ишдоржид бичсэн сурагч Санжаагийн захидлыг захидлыг авч үзвэл тэрээр тус сургуульдаа сайн суралцаж байсан нь тодорхой байна.

Тэрээр бичихдээ "... Миний бие сургуулийн ангийг дүүргэсэн эдүгээ хоёрдугаар ангид орсон тул энэхүү ангид заах зүйл болбоос ихээхэн нь урьд үзсэн зүйлээс өөр ба чухал зүйлүүд байхаас гадна тэрхүү зүйлд хэрэглэх номууд байх тул"² гэж мэдэгдэн ном худалдан авах маркийг илгээхийг хүссэнээс тодорхой байна. Иймээс сурагч Санжаа нь Герман Улсад суралцаж байхдаа тус орны нөхцөл байдалтай сайтар танилцан, тус сургуульдаа амжилттай суралцсаар байжээ.

Мөн Берлины сурагчдын нэг нь Уфа нэгдэлд Кино-гэрэл зургийн мэргэжлээр суралцаж байсан сурагч Бат-Очир юм. Тэрээр гадаад иргэдэд зориулсан хэл, бичгийн сургуульд суралцаж байгаад тодорхой хувийн шалтгааны улмаас нутаг буцсан боловч тухайн үед Монголд кино-гэрэл зургийн мэргэжлийн боловсон хүчин нэн дутагдалтай байсан учир Ардыг Гэгээрүүлэх яамны тусгай томилолтоор Герман Улсад дахин суралцах болжээ. Энэ тухай 1927 оны IX сарын 10-ны өдөр Ардыг Гэгээрүүлэх яамны сайд Эрдэнэбатхаанаас "Герман, Франц Улс дахь Монгол сурагчидын захиргаа"-ны дарга Б.Ишдоржид бичсэн захидалдаа "... Энд цахилгаан сүүдрийн сургуульд боловсорсон чадах хүнгүй тул сурагч Бат-Очирын биеийг дахин явуулав. Үүнийг хүрсэн цагт мөн цахилгаан сүүдрийн сургуульд явуулж хэрэв болбол дахин нэг жилийн дотор буюу нэг жил гаруй боловч сайтар сургуулиулаад нааш илгээх болов уу"³ гэснээс Бат-Очир нь тус яамны тусгай төлөвлөгөөний дагуу суралцаж байсан нь харагдаж байна. Сурагч Бат-Очирыг суралцаж байх хугацаанд "Герман, Франц Улс дахь Монгол сурагчидын захиргаа"-нд Ардыг Гэгээрүүлэх яамнаас даалгасны дагуу түүний сургалтад шаардлагатай мэргэжлийн техник, хэрэгслэлийг ЗХУ-аас захиалан худалдан авч ашиглуулж байжээ. Гэвч сурагч Бат-Очирын цаашид хэрхэн суралцаж байсан тухай мэдээ баримт тун ховор байна.

Лайпциг хот дахь сурагчдын аж байдал, тэдний хэрхэн суралцаж байсан тухай баримт, материал цөөнгүй байна. Анх Лайпциг хотод 1926 оны XI сараас Аюурзана, Лувсандамдин нар очиж тус хотын Wagner&Debes гэдэг газарзүйн зургийн пүүсэд дадлага хийх болсон юм. Хэдийгээр эрхлэгч багш Б. Ишдоржид Аюурзана, Лувсандамдин нараас бичсэн захидал төдийлөн ховор байгаа ч тэдний хэрхэн суралцаж байсан тухай "Герман, Франц дахь монгол

¹ УТА, Фонд № 6, данс-1, хадгаламжийн нэгж-140, хуудасны дугаар-34, захидал № 28.

² Мөн тэнд, хуудасны дугаар-35, захидал № 47.

³ УТА, Фонд № 6, данс.1, хадгаламжийн нэгж-153 хуудасны дугаар-57.

сурагчдын захиргаа"-ны 1927 оны тайлан мэдээнд тодорхой дурдсан байдаг. 1927 оны X сарын 27-ны өдөр тус захиргааны дарга Б. Ишдорж, туслах Гомбожав, эмч Эрэгзэн нар Берлин хотоос Лайпциг, Фрайберг, Айзенах, Вилккерсдорф зэрэг газруудад очиж тэнд суралцаж буй монгол сурагчдын ахуй байдал, хичээл сургуулийн байдалтай биеэр танилцсан байна. Б. Ишдорж багш улмаар сурагчдынхаа хичээл сургууль, ахуй байдалтай нь танилцсаны дараа бичсэн тайлангийнхаа 2-р хэсэгт *"Лайпциг хотноо бүхий газрын зургийн сургуулийн сурагч Аюурзана, Намжил нар эдүгээ нэгийн дор зураг зэрэгт нилээд сайнаар боловсорсон бөгөөд ер аливаа зураг үйлдэхийг бүрэн чадах болсон тул тэднийг хоёр анги болгож Аюурзаныг тусгай сургуулийн газар хэмжих зураг авах сургуульд шилжүүлэн нөгөө Намжилыг хэвээр үлдээж чулуун хороор хэвлэх сургуулийг үйлдүүлэхээр хэлэлцэн тогтов"* хэмээнээс үзвэл дээрх нэр бүхий хоёр сурагч *Wagner&Debes* пүүст ажиллаж байхдаа их зүйлийг сурч мэдэж байсан нь эргэлзээгүй юм.

Аюурзана, Лувсандамдин нар Монголын улс төрийн болон физик газарзүйн зураг хийж байсан бөгөөд *Wagner&Debes* пүүст Монголын газарзүйн полиграфи байсан бололтой. Мөн тэд хэвлэлийн арга барилд суралцахын зэрэгцээ газарзүй, геодезийн чиглэлээр давхар суралцаж байжээ. Аюурзана, Лувсаннамжил нарыг идэвхтэй, чармайлттай, сайн суралцаж байсан тухай мөн С. Вольф өгүүлэлдээ онцлон тэмдэглэсэн байдаг. Аюурзана, Лувсаннамжил нарын суралцаж байх үед *Wagner&Debes* пүүст БНМАУ-ын томоохон газарзүйн зураг 1 000 хувийг хэвлэсэнээс гадна дунд сургуулийн сургалтанд ашиглах 16 хуудастай Монголын улс төрийн болон байгалийн зургийг 10 000-ыг захиалан хийлгэсэн байна. Энэ ажилд дээрх сурагчид оролцож байсан нь тодорхой байна. Лайпциг хотод Баатарсэнгэ, Лувсандамдин нар мөн хэвлэлийн технологид суралцаж байжээ. Тэд 1927 оны III сарын 23-ны өдрөөс тус хотын *Arne Pries-I.B Hirschfeld* гэдэг томоохон хэвлэлийн пүүст ажиллах болжээ. *Arne Pries&I.B Hirschfeld* бол Лейпциг хотын хэвлэлийн алдартай пүүс байсан бололтой. Тус пүүсийн эзэн ноён Прийс, Хиршфельд нар Азийн түүх, соёлын тухай шинжлэх ухааны судалгаанд ихээхэн сонирхолтой хүмүүс байжээ. Монгол сурагчдын хэргийг эрхлэгч багш Б. Ишдорж дээрх пүүсийн эзэдтэй албаны болон хувийн зохистой харилцаатай байв. Энэ пүүст суралцаж байх хугацаандаа Баатарсэнгэ, Лувсандамдин нар ном хэвлэх арга, ажиллагаанд сайтар сурах ёстой байв.

Б. Ишдорж багш дээр дурьдсан тайландаа *"...Хэвлэлийн машины сургуулийн Дамдин, Баатарсэнгэ нар сургуульдаа сайн явж бүхий"* гэж тодорхойлсон байдаг. Тэдний аж байдал, хичээлийн тухай "Герман, Франц дахь Монгол сурагчдын захиргаа"-нд бичиж байсан захидлаас нь тодорхой мэдэж болох юм. 1928 оны IX сард сурагч Баатарсэнгээс бичсэн захидалдаа *"...Өчүүхэн бид хоёр уул сургуульдаа өдөр шөнө тасралтгүйгээр чармайн зүтгэж сурч боловсрохыг гол болгон явсаар буй болой, хэмээхээс гадна ... би үүний урьд эрхэм Прийсийн зааж өгсөн Монголын цагаан толгойг Баатар би бичиж өгсөнд Прийс их л баярлав. Ажиглаваас монгол үсгийг хийж байгаа бололтой. Эрхэм Прийс бид нарт их сайн байдаг. Та нар сайнаар хичээж гүйцэд сайн мастер болж Монголдоо буцах хэрэгтэй хэмээх мэтээр хэлмэй"* гэж бичсэн байна. Тус пүүсийн эзэн Прийс нь Баатарсэнгэ, Лувсандамдин нарт сурч боловсрох хийгээд ахуй амьдралд нь олон талаар тусалж сурагчдын гэр орноо санаж байгаа эсэх, тэдний эцэг эхийн тухай, цаашилбал Монголын тухай дэлгэрэнгүй асууж лавладаг хүн байжээ. Тус пүүсийн эзэн Прийс ийнхүү Монголд элэгтэй хүн байсан нь сурагч Баатарсэнгэ, Лувсандамдин нарт тус пүүст суралцаж, ажиллахад нь зохих дэмжлэг болж байв.

Мөн сурагч Баваасан, Цэдэндамба, Пунцаг, Сосордаваа нар Герман Улсад суралцаж байсан ч тэдэнд холбогдох тодорхой баримт олдохгүй байна. Энэ дашрамд дурьдахад монгол оюутан, сурагчидыг Герман Улсад суралцаж байх хугацаанд буюу 1927 оны XI сарын 24-ны өдөр монгол сурагч Дугаржав Берлин хотноо өвчний учир нас барсан байна. Түүнийг мөн сарын 26-ны өдөр Берлин хот дахь оршуулагын газарт оршуулж дурсгалын цагаан гантиг хөшөө босгож

*"Нөхөр Дугаржав
Монгол Улсын сурагч*

*Арван зургадугаар он, арван нэгдүгээр сарын
хорин дөрөвний өдөр наснаас нөхөцсөний дурсгал болгов"*

¹ УТА, Фонд № 6, данс. 1, хадгаламжийн нэгж-178 хуудасны дугаар-15-16.

² Мөн тэнд

³ УТА, Фонд № 6, данс. 1, хадгаламжийн нэгж-140 хуудасны дугаар-8, захидал № 7.

⁴ УТА. Үнэн сонин 1927. III. 8. № (6) 54.

гэсэн үгсийг сийлсэн байна. Сурагч Дугаржавын нас эцэслэсэн тухай "Үнэн" сонины 1927 оны III сарын 8-ны № 54-д "Герман дахь Монгол сурагчид нар" гэсэн нэртэйгээр нийтлэгдсэн дурсгалын өгүүлэлд "...Үүн дор ариун зориг төгөлдөр бөгөөд насан идэр ийнхүү хайран сэргэлэн сурагч нөхрөө алдсан нь үлдсэн бид нар үлэмж уйтгарлахаар үл барам манай Германы багш нар ч нулимсыг цуеруулсан ба бас ч тус улсын тулгуур боловсруулах хэрэгт гарзтай болсон буй заа"¹ гэжээ.

Ийнхүү БНМАУ-ын оюутан, сурагчид 1926-1930 оныг хүртэл Герман Улсад суралцаж Баруун Европын соёл, боловсролыг үр шимийг хүртэж эзэмшжээ. Тэдгээр сурагчдыг 1926-1930 онд Германд суралцах хугацаанд "Герман, Франц Улс дахь Монгол сурагчдын захиргаа" нь тэдний соёл, боловсролын бүх асуудлыг эрхлэн зохицуулж байсан бөгөөд уг үйл хэрэгт эрхлэгч багш Б. Ишдорж, туслах М. Гомбожав, С. М. Вольф, сайд Эрдэнэбатхаан, эмч Эрэгзэн, худалдааны төлөөлөгч Даш Сампилион, Хурлат нар болон БНМАУ-ын удирдах албаны олон хүмүүс түүхэн чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Баруун Европ дахь БНМАУ-ын соёл, боловсролын үйл ажиллагаа нь Герман Улстай голлон тогтож байсан ч тухайн үед Франц Улстай тогтоосон харилцаа, хамтын ажиллагааг анзаарахгүй өнгөрч болохгүй юм. Гэвч Парис дахь боловсролын үйл хэргийг энэ өгүүлэлд багтаан өгүүлэх боломжгүйгээс гадна Герман Улс дахь монгол сурагчдын ахуй амьдралтай холбоотой олон асуудлыг ч дурьдаагүй болно. Мөн түүнчлэн "Герман, Франц Улс дахь Монгол сурагчдын захиргаа"-ны үйл ажиллагаа, тухайн үеийн БНМАУ-ын удирдах хэсгээс Герман Улстай харилцах талаар гаргаж байсан хүчин чармайлт, ордлогуудын тухай энд төдийлөн дурьдаагүй билээ.

Монгол-Герман хоёр улсын харилцан ашиг сонирхол, хүчин чармайлтын үр дүнд 1926-1930 онд монгол оюутан, сурагчид Герман Улсад боловсрол эзэмшин суралцаж, Герман Улсын мэргэжилтэн боловсон хүчин БНМАУ-д уригдан ажиллаж, хоёр улсын харилцаа, хамтын ажиллагаа өргөн цар хүрээг хамран хөгжиж байжээ. Гэвч олон улсын харилцааны тэгш бус байдал, ЗХУ-ын улс төрийн ашиг сонирхолтой уг асуудал нь нийцээгүйн улмаас Монгол-Германы харилцаа, хамтын ажиллагаа тасалдахад хүрч Герман Улсад оюутан, сурагчдаа цаашид үргэлжлүүлэн сургах боломжгүй болсон юм. ЗХУ-ын шахалтанд 1928 оны X сарын 23-наас XII сарын 11-ний өдрийг хүртэл хуралдсан МАХН-ын VII Их хурлын үр дүнд БНМАУ "Герман Улс дахь оюутан, сурагчдаа буцааж татах" асуудлыг үндсэнд нь шийдвэрлэжээ². Учир нь БНМАУ дахь ЗХУ, Коминтерны нөлөө улам бүр хүчээ авч Герман тэргүүтэй өрнөдийн орнуудтай тогтоосон худалдаа, эдийн засаг, соёл, боловсролын харилцааг нэн даруй зогсоохыг БНМАУ-ын нам, засгийн удирдах хэсгээс шаардаж, элдэв шахалт үзүүлэх болсон юм. ЗХУ-ын улс төрийн шахалт, түүний нөлөөнд идэвхжсэн зүүнтний удирдагчдын улс төрийн үзэл баримтлал зэргээс шалтгаалан Баруун Европ дахь манай улсын соёл, боловсролын талаар идэвхтэй байр суурь алдагдсан юм.

Эцэст нь тэмдэглэхэд, Монгол-Германы албан бус харилцааны түүхэнд хамаарагдах 1926-1930 оны соёл, боловсролын хамтын ажиллагааны тулгуур агуулага нь улсын дайтай улс байх хэмээсэн Монголчуудын үндэсний эрх ашгаас улбаатай түүхэн эрмэлзлэлтэй холбоотой бөгөөд Өрнөдийн хөгжингүй улс, гүрнүүдээр шинэ тулгар БНМАУ-ын тусгаар тогтнолыг албан ёсоор хүлээн зөвшөөрүүлж, төрийн харилцаа тогтооход чиглэгдэж байв. Иймийн тул ЗХУ-аас гадна гадаад түншлэлийн хоёрдагч замыг сонгож, олон түшигт харилцааг төрийн бодлогынхоо үндсэн чиглэл болгон Герман Улстай худалдаа, эдийн засаг, тэр дундаа соёл боловсролын салбарт өргөн харилцаатай байжээ.

¹ УТА. Үнэн сонин 1927. III. 8. № (6) 54.

² МАХН-ын VII Их хурал, Улаанбаатар, 1980, 461 тал.



Баруун гар талаас : С. М. Вольф, Бадамжав, Мэргэн Гомбожав нар, Берлин 1926 он.



"Герман, Франц Улс дахь Монгол сурагчдын
захиргаа"-ны эрхлэгч багш Б. Ишдорж.
Берлин, 1927 он




Тус захиргааны эмч Рэгзэн.
Берлин, 1927 он



Монгол сурагчид Ардыг Гэгээрүүлэх Яамны сайд Эрдэнэбатхаан, худалдааны төлөөлөгч Даш Сампилион нарын хамт. Герман Улс, Фронау, 1926 оны зун



Монгол сурагчид анхны эрхлэгч багш Буддарын хамт. Берлин, 1926 он



БНМАУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр Герман Улсад хэвлүүлсэн Евроазийн газрын зураг.